



МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

20 21 оны 04 сарын 29 өдөр

№ 21/01

Улаанбаатар хот

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 21/07 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан болон “Мэжик консалтинг аудит” ХХК-ийн гаргасан 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



М.МӨНХБААТАР



★★



МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

20 21 оны 04 сарын 29 өдөр

№ 21/02

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалт, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрэмд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:
 - 1.1. 3.2-т “Компани нь өөрийн зорилго болон эрхлэх үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх үйл ажиллагаатай шууд буюу шууд бус холбоотой, хууль тогтоомжид хориглоогүй бүхий л төрлийн үйл ажиллагаа эрхлэх болон ажил гүйгээг хийх бүрэн эрхтэй байна.” гэснийг хасах;
 - 1.2. 4.1-т “Компанийн хараат болон охин компанийн хувьцааг эзэмшин, удирдлагаар хангах үйл ажиллагаа явуулах бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар шийдвэрлэнэ.” гэснийг хасах;
 - 1.3. 4.1-т “Компанийн эрхлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл нь:
 - 4.1.1. Аж ахуйн нэгжсийн удирдах дээд байгууллагын үйл ажиллагаа;
 - 4.1.2. Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа;
 - 4.1.3. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
 - 4.1.4. Бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ;
 - 4.1.5. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа;
 - 4.1.6. Санхүүгийн бусад үйлчилгээ.” гэж нэмэх;
 - 1.4. 4.2-т “Компанийн өөрийн зорилго болон эрхлэх үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй шууд болон шууд бус холбоотой, хууль тогтоомжид хориглоогүй бүхий л төрлийн үйл ажиллагааг эрхэлж болох бөгөөд энэ дүрэмд заагаагүй үйл ажиллагааг эрхлэх асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.” гэж нэмэх;
 - 1.5. 9.1-т “...“ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-аар тогтоох...” гэснийг “...дотоод журмаар...” гэж өөрчлөх;
 - 1.6. 9.7.20-т “Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн гишүүдийн саналаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд” гэснийг “9.7.20. Гүйцэтгэх удирдлагын гаргасан хүсэлтээр хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд”, “9.7.21. “ТУЗ-ийн дэргэдэх хороо, эсвэл ТУЗ-ийн гишүүдийн саналаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд” гэж өөрчлөх;
 - 1.7. 9.7.21 дэх заалтыг 9.7.22 дахь заалт болгож өөрчлөх;
 - 1.8. 9.8-д “...Гүйцэтгэх удирдлагын санаачилгаар...” гэснийг “...Гүйцэтгэх удирдлагын хүсэлтээр...” гэж өөрчлөх;
 - 1.9. 14.3-т “ТУЗ нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороотой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.” гэснийг “ТУЗ нь аудит, цалин, урамшуулал, нэр дэвшүүлэх болон эрсдэлийн удирдлагын хороотой байх бөгөөд аудит, цалин, урамшуулал болон нэр дэвшүүлэх хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.” гэж өөрчлөх;

★★

- 1.10.14.4-т “ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтооно.” гэснийг хасах.
2. Энэ тогтоолын 1-т заасан нэмэлт, өөрчлөлтийн талаар Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлэх болон улсын бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.
 3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ХУРЛЫН ДАРГА



М.МӨНХБААТАР



МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 29 өдөр

№ 21/03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.7 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2021 оны 3 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдээр дор дурдсан нэр дэвшигчдийг 3 жилийн хугацаатай сонгосугай. Үүнд:
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:
 - Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал Атарбаатарын Энхжин;
 - Монгол Улсын Хөгжлийн банкны Хууль, тусгай активын газрын захирлыг албан тушаалтай Бат-Ирээдүйн Анар;
 - Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирал Товуудоржийн Даваажав;
 - “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Сайнбаярын Батчимэг;
 - “Азиа Дайверсифайд Рийл Истэйт Фанд Нэг” ХХК-ийн зөвлөх Мягмарын Мөнхбаатар;
 - Капитрон банкны Бизнес хариуцсан дэд захирал Батцэнгэлийн Үүрцайхбаатар.
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр:
 - МУИС-ийн Дэд Профессор Чулуундоржийн Хашчулуун;
 - Уул уурхай металлургын цогцолбор байгуулах төслийн удирдагч Энхбаярын Шижир;
 - Мандал даатгалын ТУЗ-ийн дарга Өлзийбаярын Ганзориг.
- Энэ тогтоолын 1-г зааснаар шийдвэрлэснийг Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д тус тус мэдээлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.
- Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



М.МӨНХБААТАР

★★



МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 29 өдөр

№ 21/04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай


Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.12 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2021 оны 4 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2021 оны 5 дугаар 01-ний өдрөөс 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх цалингийн зардлын төсвийг энэ тогтоолын Хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолын Хавсралтаар батлагдсан зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



М.МӨНХБААТАР



★★



“МИК Холдинг” ХК-ийн 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 21/04 дугаар тогтоолын хавсралт

**"МИК ХОЛДИНГ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ**

Хамрах хугацаа: 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх

Зардлын төрөл	Сарын цалин		Давтамж	Хүний тоо	Нийт			Үүнээс:			
	суурь	нэмэгдэл			суурь	нэмэгдэл	нийт	2021		2022	
								суурь	нэмэгдэл	суурь	нэмэгдэл
Цалин	3,500,000	2,500,000	12	9	378,000,000	270,000,000	648,000,000	252,000,000	180,000,000	126,000,000	90,000,000
ТУЗ-ийн гишүүн	3,500,000	2,500,000	12	9	378,000,000	270,000,000	648,000,000	252,000,000	180,000,000	126,000,000	90,000,000
НДШ	465,500	332,500			50,274,000	35,910,000	86,184,000	33,516,000	23,940,000	16,758,000	11,970,000
Нийт зардал	3,965,500	2,832,500	12	9	428,274,000	305,910,000	734,184,000	285,516,000	203,940,000	142,758,000	101,970,000